



ТӨВ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 05 сарын 21 өдөр

Дугаар А/254

Зуунмод

Захиалагч шинэчлэн байгуулах, эрх шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2, 60.1.5 дахь хэсэг, 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.7 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн 2025 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, нэмэлт төлөвлөгөөнд батлагдсан Шилжих үлдэгдлийн эх үүсвэрээс хэрэгжүүлэх ТӨАХААГ/20250201085 дугаартай "3х3 сагсан бөмбөгийн талбай байгуулах (Лүн сум)" төсөл, арга хэмжээний захиалагчаар Лүн сумын Засаг дарга, аймгийн Замын сангийн хөрөнгөөр хэрэгжих ТӨАХААГ/20250202017 дугаартай "Автозамын тэмдэгжүүлэлт (Сумдад, мэдээллийн тэмдэг)" төсөл, арга хэмжээний захиалагч байгууллагаар Зуунмод сумын Засаг дарга хэрэгжүүлэхээр шинэчлэн байгуулсугай.

2. ТӨАХААГ/20250201085 дугаартай "3х3 сагсан бөмбөгийн талбай байгуулах (Лүн сум)" төсөл, арга хэмжээ, ТӨАХААГ/20250202017 дугаартай "Автозамын тэмдэгжүүлэлт (Сумдад, мэдээллийн тэмдэг)" төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулах эрхийг Зуунмод, Лүн сумын Засаг даргад шилжүүлсүгэй.

3. Аймгийн Засаг даргын 2024 оны А/822 дугаар захирамжийн хоёрдугаар хавсралт замын сангийн жагсаалтын 5 дугаарт, 2025 оны А/212 дугаар захирамжийн хоёрдугаар хавсралт орон нутгийн хөгжлийн сангийн шилжих үлдэгдэл жагсаалтын 17 дугаарт батлагдсан төсөл, арга хэмжээний захиалагч байгууллагыг хүчингүй болгосугай.

4. Захирамжид заасан төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг холбогдох хууль, тогтоомжийн дагуу ашиг сонирхлын зөрчил, авлигаас ангид байх зарчмыг баримтлан Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn)-ээр шуурхай зохион байгуулж, тендерийн урилга, төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил, үр дүн, гэрээ, ажил хүлээж авсан актыг тухай бүр цахим системд нийтэлж ажиллахыг сумын Засаг дарга, захиалагч нарт, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого, төлөвлөлтийн хэлтэс (Э.Уянга)-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Л.ТӨМӨРЧӨДӨР

4125010745

